



## САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ ТОГТООЛ

2017 оны 7 сарын 20 өдөр

Дугаар 1149

Улаанбаатар хот

Хадгаламж, зээлийн үйл ажиллагаа эрхлэх  
тусгай зөвшөөрлийг түдгэлзүүлэх тухай

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.3, Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1.4, Хадгаламж, зээлийн хоршооны тухай хуулийн 56 дугаар зүйлийн 56.2.4 дэх заалт, Санхүүгийн зохицуулах хорооны 2015 оны 405 дугаар тогтоолоор баталсан "Хадгаламж, зээлийн хоршооны үйл ажиллагааны зохицуулалтын журам"-ын 8.1.2, 8.1.3 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Энэхүү тогтоолын хавсралтад дурдсан нэр бүхий 7 ХЗХ-ны хадгаламж, зээлийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг 3 сар хүртэл хугацаагаар түдгэлзүүлсүгэй.
2. Тусгай зөвшөөрлийг түдгэлзүүлсэн хугацаанд гаргасан зөрчлөө арилгаж, энэ талаар Санхүүгийн зохицуулах хороонд мэдэгдээгүй тохиолдолд хадгаламж, зээлийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг хүчингүй болгох арга хэмжээ авахыг хавсралтад дурдсан нэр бүхий 7 ХЗХ-ны удирдлага, эрх бүхий албан тушаалтанд анхааруулсугай.
3. Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж, олон нийт болон харьяалагдах татварын албанд ажлын 10 хоногийн дотор мэдээлэхийг Ажлын алба /Г.Жамбаажамц/-нд даалгасугай.

ДАРГА



С.ДАВААСҮРЭН

Санхүүгийн зохицуулах хорооны  
2017 оны 7 дугаар сарын 20-ны өдрийн  
149-т тоот тогтоолын хавсралт



№	ББСБ-уудын нэр	Регистрийн дугаар	Банк бус санхүүгийн үйл ажиллагааны төрөл	Хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ /төгрөгөөр/
1	"Арвинбураат ББСБ" ХХК	5712211	Зээл	800,000,000
2	"Ачиткапитал ББСБ" ХХК	5900581	Зээл	800,000,000
3	"Фин-Инвест ББСБ" ХХК	2707454	Зээл	800,000,000
4	"И Зэт Би финанс ББСБ" ХХК	5777089	Зээл	800,000,000
5	"Майкро кредит инвестмент ББСБ" ХХК	5804922	Зээл	801,000,000
6	"Танилгрупп ББСБ" ХХК	5267498	Зээл	810,000,000
7	"Гео финанс ББСБ" ХХК	5961548	Зээл	820,000,000
8	"Фундаментал ББСБ" ХХК	5524636	Зээл, гадаад валютын арилжаа	1,000,000,000